

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/09/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/227  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Д.БАТБИЛЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Сүмбэр сум тайлант онд Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Сүмбэр сум хүртэлх 14.5 км хатуу хучилттай замын зураг төсвийг хийж гүйцэтгэсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн ундны усны худаг засвар, төв зам дагуух ногоон байгууламж, Жавхлант хороололд гэрэлт цамхаг, сумын төвийн тохижилт явган хүний зам тавих, хүүхдийн тоглоомын талбай зэрэг бүтээн байгуулалтын ажлыг 150,400.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 20-ны 02 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 43 зорилт 177 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 91,6%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Тайлант онд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 2,820,415.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 171,757.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан байна.

G/Архив/Alban bichig 2023/ A4  
19030295

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		852,046.0	563,460.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	145,562.2	145,183.9
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	448,469.1	324,882.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	258,014.8	93,393.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,339,666.1	860,930.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,339,666.1	860,930.9
39200	Биет хөрөнгө		3,283,306.5	847,573.9
39300	Биет бус хөрөнгө	13	56,359.6	13,357.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,191,712.1	1,424,391.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		32,711.8	8,220.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	32,711.8	8,220.3
41300	Өглөг	17а, 17б	32,711.8	8,220.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,159,000.3	1,416,171.2
51	Засгийн газрын хувь оролцоо		4,159,000.3	1,416,171.2
51100	Засгийн газрын оруулсан капитал		886,567.9	372,566.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		886,567.9	372,566.7
51200	Хуримтлагдсан үр дүн		1,409,667.2	790,998.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,862,765.2	252,606.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,191,712.1	1,424,391.5

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,311,403.90	2,301,322.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО		63,088.20	200,793.00
110	Орлогын албан татвар		28,153.60	142,646.90
1100	Хувь хүний орлогын албан татвар		28,153.60	148,822.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0	-6,176.00
113	Хөрөнгийн албан татвар		18,425.80	36,742.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		16,508.80	21,403.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	295,352.10	456,734.20
120	Нийтлэг татварын бус орлого		295,352.10	456,734.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,952,963.60	1,643,795.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,213,806.20	1,935,673.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,213,806.20	1,900,673.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,333,735.80	1,097,227.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,338,059.00	268,661.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		171,774.20	27,766.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		293,673.20	298,281.60
2104	Хангамж, бараа материалын зардал		81,104.60	168,400.10
2105	Нормативт зардал		137,643.40	86,131.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,572.60	3,844.80
2107	Томилолт, зочны зардал		2,553.50	3,591.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,210.60	92,542.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		288,144.80	148,007.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		880,070.30	803,446.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	35,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		97,597.70	365,649.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,075.00	2,992,172.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		96,522.70	-2,626,522.80

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,061,574.2	0.0	4,061,574.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	903.4	0.0	903.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,062,477.6	0.0	4,062,477.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	96,522.7	0.0	96,522.7
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,159,000.3	0.0	4,159,000.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,159,000.3	0.0	4,159,000.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,686,119.3	0.0	-2,686,119.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,472,881.0	0.0	1,472,881.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-2,626,522.8	0.0	-2,626,522.8
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,416,171.2	0.0	1,416,171.2

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,160,076.30	1,108,717.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	63,088.20	200,793.00
110	Орлогын албан татвар	28,153.60	142,646.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	28,153.60	148,822.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-6,176.00
113	Хөрөнгийн албан татвар	18,425.80	36,742.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,508.80	21,403.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,815.90	6,530.60
1181	Газрын төлбөр	6,155.80	13,768.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	537	1,104.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,874.50	187,514.30
120	Нийтлэг татварын бус орлого	142,874.50	187,514.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,954,113.60	720,410.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,011,281.70	875,177.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,011,281.70	875,177.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,129,949.10	863,978.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,312,643.50	259,902.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,448.90	32,530.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,529.40	298,612.40
2104	Хангамж, бараа материалын зардал	137,395.70	108,463.40
2105	Нормативт зардал	111,371.50	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,019.40	5,200.00
2107	Томиллолт, зочны зардал	2,609.50	3,647.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,585.70	39,699.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,345.60	115,923.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	881,332.50	11,199.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	148,794.60	233,540.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	28,199.50	188,918.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,199.50	188,918.30
2200	Дотоод эх үүсвэрээр	28,199.50	188,918.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-28,199.50	-188,918.30
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-23,600.00	-45,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	23,600.00	45,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	96,995.10	-378.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,567.00	145,562.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	145,562.20	145,183.90

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>985,860.50</b>	<b>915,767.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>700,919.40</b>	<b>681,849.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>699,919.40</b>	<b>681,349.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>261,036.80</b>	<b>257,340.25</b>
210101	Үндсэн цалин	204,705.40	203,353.83
210102	Нэмэгдэл	49,520.10	39,170.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	298.00
210104	Урамшуулал	6,811.30	14,459.55
210105	Гэрээт ажлын хөлс	-	58.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,784.90</b>	<b>32,530.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,165.50	22,394.83
210202	Тэтгэмжийн даатгал	2,654.90	2,583.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,124.00	2,052.88
210204	Ажилгүйдлийн даатгал	530.90	479.24
210205	Эрүүл мэндийн даатгал	5,309.60	5,019.99
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>310,747.70</b>	<b>298,421.71</b>
210301	Гэрэл, цахилгаан	29,015.60	24,163.46
210302	Түлш, халаалт	271,835.90	265,157.96
210303	Цэвэр, бохир ус	9,896.20	9,100.30
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,293.20</b>	<b>22,293.20</b>
210401	Бичиг хэрэг	1,523.50	1,523.50
210402	Тээвэр, шатахуун	13,673.70	13,673.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,786.00	1,786.00
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,310.00	5,310.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,202.00</b>	<b>5,200.00</b>
210604	Урсгал засвар	5,202.00	5,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,689.80</b>	<b>3,647.50</b>
210702	Дотоод албан томилолт	3,689.80	3,647.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,148.00</b>	<b>39,147.13</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,798.00	37,798.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420.00	420.00
210803	Даатгалын үйлчилгээ	400.00	400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228.00	228.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	302.00	301.13
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,017.00</b>	<b>22,769.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,517.00	20,269.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500.00	2,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,000.00</b>	<b>500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000.00</b>	<b>500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.00	500.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>214,941.10</b>	<b>188,918.29</b>
221001	Их засвар	127,316.00	101,530.16
222001	Тоног төхөөрөмж	39,000.00	39,000.00
223001	Бусад хөрөнгө	48,625.10	48,388.13
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>70,000.00</b>	<b>45,000.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	70,000.00	45,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>985,860.50</b>	<b>905,411.83</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>119,547.30</b>	<b>119,547.30</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	119,547.30	119,547.30
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>720,919.40</b>	<b>732,700.26</b>
320001	Орон нутгийн төсвөөс	720,919.40	732,700.26
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>145,393.80</b>	<b>53,164.27</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	49,279.01
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,885.26
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	75,393.80	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	41,729.92
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	31,373.86
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>94.00</b>	<b>78.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>46.00</b>	<b>38.00</b>
620001	Удирдах ажилтан	7.00	6.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	17.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>46.00</b>	<b>38.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31.00	24.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.00	5.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>250,910.9</b>	<b>57,376.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>234,681.9</b>	<b>57,376.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	156,665.6	42,769.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	38,053.5	-
210101	Үндсэн цалин	30,327.9	-
210104	Урамшуулал	7,725.7	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,784.0	-
210201	Тэтгэврийн даатгал	3,784.0	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,729.8	315.9
210401	Бичиг хэрэг	159.8	-
210402	Тээвэр, шатахуун	1,570.0	315.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	73,214.8	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,914.8	-
210502	Хоол, хүнс	13,300.0	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	370.4	300.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	370.4	300.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,513.0	42,153.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,435.0	42,153.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78.0	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,016.3</b>	<b>14,606.6</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	73,957.2	5,100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,195.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,754.2	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008.0	-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,059.1	9,506.6
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4,059.1	9,506.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,229.0</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>16,229.0</b>	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,229.0	-
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>251,119.8</b>	<b>57,167.4</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>251,119.8</b>	<b>57,167.4</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,536.5	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	216,678.2	57,167.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,905.1	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	208.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	208.9	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга “Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн сумын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сум тайлант онд Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Сүмбэр сум хүртэлх 14.5 км хатуу хучилттай замын зураг төсвийг хийж гүйцэтгэсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн ундны усны худаг засвар, төв зам дагуух ногоон байгууламж, Жавхлантай хороололд гэрэлт цамхаг, сумын төвийн тохижилт явган хүний зам тавих, хүүхдийн тоглоомын талбай зэрэг бүтээн байгуулалтын ажлыг 150,400.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 20-ны 02 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 43 зорилт 177 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 91,6%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29, 2022 оны 7 дугаар сарын 01, 2022 оны 8 дугаар сарын 29, 2022 оны 12 дугаар сарын 09-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Сумын дотоод хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөл байгуулж, журам батлах тухай" Б/01 тоот захирамж гаргаж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын дотоод хяналт шинжилгээ үнэлгээний баг тайлант онд дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө боловсруулан Засаг даргын тамгын газрын даргаар батлуулан зохион байгуулах 11 арга хэмжээ боловсруулан хэрэгжилтийг гарган 99,9 хувьтай гэж дүгнэсэн байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,767,320.6 мянган төгрөгөөр буюу 34,0 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	145,562.2	145,183.9	-378.3
Авлага	448,469.1	324,882.8	-123,586.3
Бараа материал	258,014.8	93,393.9	-164,620.9
Үндсэн хөрөнгө	3,339,666.1	860,930.9	-2,478,735.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,191,712.1</b>	<b>1,424,391.5</b>	<b>-2,767,320.6</b>
Өр төлбөр	32,711.8	8,220.3	-24,491.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,159,000.3	1,416,171.1	-2,742,829.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,191,712.1</b>	<b>1,424,391.5</b>	<b>-2,767,320.6</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 378.3 мянган төгрөгөөр буурч 145,183.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь тайлант онд орон нутгийн орлого 110,345.8 мянган төгрөг нь орон нутгийн орлогын үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 18,575.4 мянган төгрөгийн хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сан 12,798.4 мянган төгрөг нь зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн мөнгө, 3,464.2 мянган төгрөгийн эм эргэлтийн сангийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 324,882.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 123,586.3 мянган төгрөгөөр буурсан нь Орон нутгийн хөгжлийн сан 4,489.1 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сан 6,570.0 мянган төгрөгөөр, Эмийн эргэлтийн сан 876.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв 133,936.5 мянган төгрөгөөр бууруулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93,393.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 164,620.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 171,757.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 860,930.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,478,735.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,820,415.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 8,220.3 мянган төгрөг болж 24,491.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын 98.2 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 1,150.0 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 6,116.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 855.9 мянган төгрөгийн өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 1,416,171.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,742,829.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,626,522.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 145,183.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 378.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>			
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>145,562.2</b>	<b>145,183.9</b>	<b>-378.3</b>
<b>Төгрөг</b>	145,562.2	145,183.9	-378.3
Төрийн сангийн харилцах	112,551.5	141,719.7	29,168.2
Арилжааны банк дахь харилцах	33,010.7	3,464.2	-29,546.5
<b>Дүн</b>	<b>145,562.2</b>	<b>145,183.9</b>	<b>-378.3</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн хөрөнгийн тодруулга тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 145,183.9 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 141,719.7 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 3,464.2 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 145,183.9 мянган төгрөгийн 76,0 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 110,345.8 мянган төгрөг, 12,8 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 18,575.4 мянган төгрөг, 8,8 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 12,798.4 мянган төгрөг, Эм эргэлтийн сангийн 2,4 хувь буюу 3,464.2 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 378.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 39,733.1 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,179.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, 6,871.2 мянган төгрөгөөр, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,873.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 29,546.5 мянган төгрөгөөр буурсан байна.

### Аудитын илрүүлэлт

1.Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 16,131.2 мянган төгрөгийн 4 ажлын хүлээн авсан комиссын акт байхгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

2.Соёлын төв номын санч Ч.Шоовдорт 2022 оны 8-12 саруудад цалинг бодож олгохдоо хавсран ажилласны нэмэгдэл цалинг буруу бодож, илүү олгосон 296,172.40 төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.Эмийн эргэлтийн сан Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т "дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор", Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр тушаалын 101.1-т "Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагналыг урамшууллаас бүрдэнэ." гэсэн заалтыг зөрчиж, 2,847,050.7 мянган төгрөгийн урамшууллаас НДШ тооцоогүй 599.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тайлант онд хурлын төлөөлөгч нарт 500.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 324,882.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 123,586.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	98.3	265.9	167.6
Байгууллагаас авах авлага	158,496.5	28,172.5	-130,324.0
Хувь хүмүүсээс авах авлага	289,874.3	296,444.3	6,570.0
<b>Дүн</b>	<b>448,469.1</b>	<b>324,882.8</b>	<b>-123,586.3</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн авлагын тодруулга тайлан

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 295,494.3 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 90,9 хувийг, байгууллагаас авах орон нутгийн хөгжлийн сангаар хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын дутуу ажлын авлага 26,936.5 мянган төгрөг буюу 8,3 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 324,882.8 мянган төгрөгийн 91,2 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 8,8 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 93,393.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 164,620.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>23,872.5</b>	<b>14,495.6</b>	<b>-9,376.9</b>
Тусгай зориулалттай материал	254.2	-	-254.2
Эм боох материал	23,618.3	14,495.6	-9,122.7
<b>Хангамжийн материал</b>	<b>234,142.3</b>	<b>78,898.2</b>	<b>-155,244.1</b>
Бичиг хэргийн материал	4,810.9	980.0	-3,830.9
Аж ахуйн материал	71,677.2	15,406.0	-56,271.2
Сэлбэг хэрэгсэл	449.0	329.0	-120.0
Түлш, шатах тослох материал	972.3	-	-972.3
Барилгын засварын материал	357.6	-	-357.6
Хүнсний материал	3,373.0	-	-3,373.0
Бусад хангамжийн материал	152,502.4	62,183.3	-90,319.1
<b>Дүн</b>	<b>258,014.8</b>	<b>93,393.9</b>	<b>-164,620.9</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 93,393.9 мянган төгрөгийн 83,3 хувь буюу 77,806.0 мянган төгрөгийг Засаг даргын тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 469.0 мянган төгрөг буюу 0,5 хувийг, Эмийн эргэлтийн сангийн 15,118.0 мянган төгрөг буюу 16,2 хувийг бараа материал эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 127,515.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 171,757.3 мянган төгрөг, зарцуулсан 120,379.1 мянган төгрөг нийт 292,136.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 860,930.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,478,735.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>3,283,306.5</b>	<b>847,573.9</b>	<b>-2,435,732.6</b>
Барилга, байгууламж, орон сууц	3,460,149.1	755,272.8	-2,704,876.3
Авто-тээврийн хэрэгсэл	169,698.3	243,527.4	73,829.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	388,093.4	183,510.1	-204,583.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	166,606.5	45,143.9	-121,462.6
Зам, гүүрний байгууламж	536,275.4	536,275.4	0
Бусад үндсэн хөрөнгө	26,246.0	19,598.9	-6,647.1
Ном	10,323.7	124.0	-10,199.7
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>56,359.6</b>	<b>13,357.0</b>	<b>-43,002.6</b>
Программ хангамж	4,996.5	3,171.5	-1,825.0
Бусад биет бус хөрөнгө	55,281.0	13,357.0	-41,924.0
<b>Дүн</b>	<b>3,339,666.1</b>	<b>860,930.9</b>	<b>-2,478,735.2</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үндсэн хөрөнгийн тодруулга тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 98,5 хувь буюу 848,134.5 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,2 хувь буюу 1,805.2 мянган төгрөгийг ИТХ, 1,3 хувь буюу 10,991.2 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 860,930.9 мянган төгрөг болж, худалдан авсан 392,560.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 2,820,415.1 мянган төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн 697,309.6 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 862,286.3 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 363,013.1 мянган төгрөгийн, Соёлын төвийн 897,806.0 мянган төгрөгийн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

1. Эм эргэлтийн сангийн хөрөнгөөр эмнэлгийн ажилчдын орон сууц 51,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 9 дүгээр сарын 16-ны 297 дугаар "эмийн эргэлтийн сангийн ажиллах журам"-ын 3.4-т "ЭЭС-ийн эргэлтийн хөрөнгийг дээрх үйл ажиллагааг санхүүжүүлээд үлдсэн цэвэр ашгаас эмийн санчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, идэвх санаачилгатай ажилласан ЭЭС-ийн удирдах зөвлөлийн гишүүд, эмийн санч, нягтлан бодогч болон эмнэлгийн мэргэжилтнийг урамшуулахад зарцуулж болно" гэсэн заалтыг зөрчсөн зөрчилд албан шаардлага өгсөн.

**3.5.7 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 8,220.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 24,491.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	25,601.3	285.7	-25,315.6
Байгууллагад төлөх өглөг	98.2	98.2	0.0
Хувь хүмүүст төлөх өглөг	7,012.3	7,836.5	824.2
<b>Дүн</b>	<b>32,711.8</b>	<b>8,220.3</b>	<b>-24,491.5</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 8,220.3 мянган төгрөг болж, 24,491.5 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан нь Засаг даргын тамгын газар 98.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 25,503.0 мянган төгрөгөөр буурч эм эргэлтийн сангийн өглөг 855,9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Орон нутгийн ерөнхий орлого 98.2 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 1,150.0 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 6,116.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 855.9 мянган төгрөг нийт 8,220.3 мянган төгрөгийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,424,391.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,767,320.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	886,567.9	372,566.7	-514,001.2
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,409,667.1</b>	<b>790,998.4</b>	<b>-618,668.7</b>
Өмнөх үеийн үр дүн	1,313,144.4	3,417,521.2	2,104,376.8
Тайлант үеийн үр дүн	96,522.7	-2,626,522.8	-2,723,045.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,862,765.2	252,606.0	-1,610,159.2
<b>Дүн</b>	<b>4,191,712.1</b>	<b>1,424,391.5</b>	<b>-2,767,320.6</b>

Эх сурвалж: Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нээгээсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,424,391.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,767,320.6 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр Засгийн газрын сан 514,001.2 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 1,610,159.2 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 2,104,376.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 2,723,045.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Сүмбэр сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 808,019.7 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 178,618.7 мянган төгрөг, 2022 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 986,638.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 5 дугаар тогтоолд зааснаар Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд 178,618.7 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 655,578.6 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 119,547.3 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 32,893.8 мянган төгрөг нийт 986,638.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 5 дугаар тогтоолд зааснаар Сүмбэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 178,618.7 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр хэвээр баталж гүйцэтгэлээр 224,830.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 125,8 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх хадгаламжийн хүүгийн орлого 2,979.3 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 469.4 мянган төгрөгөөр, түрээсийн орлого 370.0 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2,232.0 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 3,308.7 нийт 9,359.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор орон нутагт төвлөрүүлэх төсвийн орлогыг 178,618.7 мянган төгрөгөөр хэвээр баталж, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 113,277.8 мянган төгрөгөөр бууруулан 542,300.8 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 52,893.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 172,441.0 мянган төгрөгөөр, сумын орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлийг 42,500.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын төсвийн жилд зарцуулах зардлын хэмжээг 896,608.5

мянган төгрөгөөр тодотгон баталсан дүн төсвийн жилд зарцуулах эх үүсвэрийн дүнгээс 39,252.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, аймаг болон сангийн яамны е тайлангийн төлөвлөгөөнөөс 50,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 7 дугаар тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 100,000.0 мянган төгрөгөөр баталсан ч аймаг болон Сангийн яамны е тайлангийн төлөвлөгөө 70,000.0 мянган төгрөг буюу 30,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тодотгон баталсан тогтоол байхгүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 178,618.7 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 542,300.7 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 119,547.3 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 75,393.8 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 70,000.0 мянган төгрөгийг нийт 985,860.5 мянган төгрөг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 914,430.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 36,240.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 916,163.2 мянган төгрөг буюу 92,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 69,697.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь шалтгаалсан байна. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн зардал 24,900.0 мянган төгрөгөөр хэмнэсэн нь шаардлага хангасан төсөл хөтөлбөр ирүүлээгүйгээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 3 төсөл, 9 арга хэмжээнд 214,941.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 188,918.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	53,423.3	52,338.7	1,084.6	98.0
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- үндсэн үйл ажиллагааны зардал	353,274.2	348,044.7	5,229.5	98.5
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	136,323.4	135,718.9	604.5	99.6
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	82,484.0	72,697.3	9,786.7	88.1
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	87,277.5	85,772.6	1,504.9	98.3
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	30,637.0	30,072.7	564.3	98.2
7	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	70,000.0	45,100.0	24,900.0	64.4
8	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	172,441.1	146,418.3	26,022.8	84.9
9	<b>Дүн</b>	<b>985,860.5</b>	<b>916,163.2</b>	<b>69,697.3</b>	<b>92.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 57,167.4 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 208.9 мянган төгрөг нийт 57,376.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 51,963.8 мянган төгрөг зарцуулж, 5,412.5 мянган төгрөг Засаг даргын тамгын газар орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг төгөлдөржүүлнэ.	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд цахим салбарыг дэмжиж иргэдэд нээлттэй хүртээмжтэй байлгах зорилгоор мэдээ мэдээллийг цахимаар тогтмол хүргэж цахимаар иргэдэд үйлчлэх боломжийг бүрдүүлэн ажилласан. Хэрэгжилт 100%	53,423.3	52,338.7
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 12 зорилт, хэрэгжүүлэх 34 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98,5%	353,274.2	348,044.7
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу 3 чиглэлээр шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох.	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэлтийн хөрөнгө болон үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг үр дүнтэй санхүүжүүлсэн. Хэрэгжилт 64,4%	70,000.0	45,100.0
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	“Оюунлаг Төв аймаг” хөтөлбөр хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулан, үр дүнг ахиулна.	ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлж, урамшуулал олгох зорилго бүхий гүйцэтгэлийн үнэлгээг Боловсролын үнэлгээний төвөөс хүргүүлсэн удирдамж, зааварчилгааны дагуу зохион байгуулсан. Багш нарын гүйцэтгэлийн дундаж 72.5%-тай шалгагдсан.	136,323.4	135,718.9
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургууль, цэцэрлэг бүр хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг дэмжих замаар хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлнэ.	Сургалт үйл ажиллагааг дэмжих замаар 8 төрлийн дугуйлангийн үйл ажиллагааг явуулж 109 хүүхдийг хамруулсан байна.Уран жиргээ, даамны тэмцээний зохион байгуулсан. ЯРГУИ-2022 уралдаанд дууны төрөлд мөнгөн , бүжгийн төрөлд тусгай байр эзэлсэн. Хэрэгжилт 100%	82,484.0	72,697.3
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Нийтийн биеийн тамир, урлаг,спортын чиглэлээр нийтийг хамарсан үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ 24 арга хэмжээ зохион байгуулж 850 иргэнийг хамруулсан	2022 оны байдлаар 13 удирдамжаар 16 төрлийн спортын арга арга хэмжээ зохион байгуулсан. 5 төлийн тэмцээнд 776 иргэн хамрагдсан. Хэрэгжилт 91,3%	87,277.5	85,772.6
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо Эрүүл мэндийн байгууллагын тоног, төхөөрөмжийн стандарт хангалтыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.	Артерийн гипертензи илрүүлэх үзлэгт 1105 иргэнийг хамруулахаас 1107 иргэнийг хамруулсан.Чихрийн шижин өвчний илрүүлэг үзлэгт 699 иргэн хамрагдахаас 735 иргэн хамрагдсан. Хөхний хавдрын үзлэгт 368 иргэн хамрагдахаас 368 иргэнийг хамруулсан. Хамралт-100%	30,637.0	30,072.7
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Суманд 3-аас доошгүй хүүхдийн тоглоомын талбай, 1000-аас доошгүй м <sup>2</sup> явган зам, 1-ээс доошгүй биеийн тамирын талбай, 2-оос доошгүй км дугуйн зам байгуулах ажлыг иргэд, аж ахуйн нэгжийн оролцоо дэмжлэгтэй хэрэгжүүлнэ	Төвийн ундны усны худаг засвар, төв зам дагуух ногоон байгууламж тохижилт, Жавхлантай хорооллын гэрэлт цамхаг, Золбин нохой устгалд, сумын төвийн тохижилт явган хүний зам тавих, Бага бор болон халуун гууны худаг засвар, Огтоно устгалын зардалд, Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 84,9%	172,441.1	146,418.3

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 06/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 1,029,138.4 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 10,291.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,204.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн жилд цалин хөлс, НДШ-ийн зардал 5,951.4 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 12,325.9 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 42.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 247.2 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 500.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 26,022.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 75.0 хувь, 5,0 саяас дээших орлогын 37 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 43 шийдвэр, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 5 мэдээлэл байршуулахаас 681,556.0 мянган төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 43 шийдвэр байршуулаагүй байна.

#### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэлээ.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх онд Сүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийгдээгүй татгалзсан дүгнэлт авсан байна.

#### **4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 692,896.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 692,896.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

1. Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үнэ төлбөргүй гарсан зардлын дүнгээс үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн дүн 566,498.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлын дүнгээс бараа материалын тодруулга тайлангийн бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн дүн 126,398.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 881,022.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 881,022.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

#### **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### Илрүүлэлт:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх орлогыг 59,389.5 мянган төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх орлогыг 11,465.1 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх орлогыг 9,359.4 мянган төгрөгөөр нийт 80,214.0 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, аймаг, орон нутгийн 3 шатны орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.

2. Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын төсвийн жилд зарцуулах зардлын хэмжээг 896,608.5 мянган төгрөгөөр тодотгон баталсан дүн төсвийн жилд зарцуулах эх үүсвэрийн дүнгээс 39,252.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, аймаг болон Сангийн яамны е тайлангийн төлөвлөгөөнөөс 50,000.0 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр 30,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нийт 119,252.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6.6.4-д “төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх”, 7 дугаар зүйлийн 7.5-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталсан өдрөөс эхлэн зохион байгуулж болно”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ-аар баталсан тогтоолын дүн аймаг, сангийн яамны е тайлангийн төлөвлөгөөнөөс зөрүүтэй байх.

3. Тус байгууллага тайлант онд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 75.0 хувь, 5,0 саяас дээших орлогын 37 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 43 шийдвэр, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 5 мэдээлэл байршуулахаас 681,556.0 мянган төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 43 шийдвэр байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10

1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1			
2	Засаг даргын тамгын газар	1	1			1	
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1			
4	Эмийн эргэлтийн сан	1		1			
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1			
<b>НИЙТ</b>		<b>5</b>	<b>1</b>	<b>4</b>		<b>1</b>	

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	692,896.8			1	692,896.8	1	692,896.8		
ЗДТГ	2	310,906.8	2	310,906.8			2	310,906.8		
Хоршоо хөгжүүлэх сан	2	6,416.1			2	6,416.1	2	6,416.1		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1,010,219.7</b>	<b>2</b>	<b>310,906.8</b>	<b>3</b>	<b>699,312.9</b>	<b>5</b>	<b>1,010,219.7</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	199,466.0					2	199,466.0
ИТХ	1	500.0	1	500.0				
ЗДТГ	2	12,935.5	1	1,472.7	1	11,462.8		
Сум хөгжүүлэх сан	1	296.2	1	296.2				
Орон нутгийн хөгжлийн сан	1	16,131.3					1	16,131.3
Эргэлтийн эмийн сан	1	51,599.8	1	599.8	1	51,500.0		
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>280,928.8</b>	<b>4</b>	<b>2,868.7</b>	<b>2</b>	<b>62,962.8</b>	<b>2</b>	<b>215,597.3</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	681,556.0					1	681,556.0
ЗДТГ	1	159,843.6					1	159,843.6
Орон нутгийн хөгжлийн сан	1	229,134.3					1	229,134.2
Хоршоо хөгжүүлэх сан	1	49,562.6					1	49,562.6
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1,120,096.4</b>					<b>5</b>	<b>1,120,096.4</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	34,888.7			1	34,888.7		
Дүн	1	34,888.7			1	34,888.7		
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>1,154,985.1</b>			<b>1</b>	<b>34,888.7</b>	<b>5</b>	<b>1,120,096.4</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)